



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

додгч оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/КБ

Улаанбаатар хот

Бог малын төлийг мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтад хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/315 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1099 дүгээр захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэр дэх бог малын төлийг мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий нийт 4400 толгой мал, амьтныг вакцинжуулалтад бүрэн хамруулахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, дархлаажуулалт хийх товлосон хугацаанд, малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж, ажиллахыг 1 дүгээр хороо (Н.Нямзав) 2 дугаар хороо (Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү, тариур, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тос материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4. Дархлаажуулалтад шаардагдах 2.046.800 (Хоёр сая дөчин зургаан мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг, үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 27 ны өдрийн 718 дугаар
захирамжийн хавсралт



БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН
ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн
зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	195	2410	469,950.00
2	Тариур	ш	500	400	200,000.00
3	Зүү	ш	500	700	350,000.00
4	Нэг удаагийн маск	ш	100	200	20,000.00
5	Нэг удаагийн малгай	ш	100	200	20,000.00
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000.00
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000.00
8	Шатахуун А-92 (вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад)	л	85	2410	204,850.00
Дүн					1,346,800.00

2. Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700,000.00
Дүн						700,000.00
НИЙТ ДҮН						2,046,800.00